

**АКАДЕМИЧИЙН 70 НАСНЫ ОЙД**

**Академич Н.Ишжамц бол Монголын  
түүхийн томоохон мэргэжилтэн, нэрт  
эрдэмтэн мөн**

*Дэд доктор С.ДАШЦЭВЭЛ*

Академич Нямбуугийн Ишжамц 1928 онд Дорноговь аймгийн Хөвсгөл суманд төрж, Дорноговийн дунд сургууль, Улаанбаатар дахь Улсын Их сургуулийн бэлтгэл ангид суралцаад 1953 онд Москвагийн Их сургуулийг түүхч, хятад судлалын мэргэжлээр дүүргэжээ. Ийнхүү 1950-иад оны эхээр орос, хятад, англи хэлтэй, онолын шинэ мэдлэгтэй залуу мэргэжилтэн Монголын түүхийн шинжлэх ухааны үүдийг татжээ. Н.Ишжамц шинжлэх ухааны Хүрээлэнгийн түүхийн тасагт 4 жил орчим ажиллаж байгаад БНХАУ-ын Бээжингийн Их сургуулийн аспирантурт суралцан төгсч 1962 онд түүхийн ухааны дэд докторын зэрэг, 1972 онд Москвагийн Их сургуульд түүхийн ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан байна.

Н.Ишжамц Москвагийн Их сурууль дөнгөж төгсч ирээд байсан 1950 иад оны дундуур Монголын түүхчдийн өмнө манжийн үеийн монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, түүний зэвсэгт тэмцлийн түүхийг нарийвчлан судалж, шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байжээ. Тэрхүү эрэлт шаардлагын дагуу залуу судлаач уг сэдвийг сонгон авчээ.

Н.Ишжамц Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, түүний зэвсэгт тэмцлийг тухайлан судалж хэд хэдэн бүтээл туурвисан байна. Үүнд: 1955 онд "Манжийн дарлалыг эсэргүүцсэн Монголын ард түмний 1955-1957 оны зэвсэгт бослого", 1962 онд "Монголын ард түмний тусгаар тогтнолын Зэвсэгт Тэмцэл Амарсанаа, Чингүнжав нарын бослого/" хэмээх бүтээлүүдийг туурвижээ. Ийнхүү Монголын ард түмний тусгаар тогтнолын тэмцэл, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг ул суурьтай судалсан монголын цөөн хэдэн эрдэмтний нэг болсон байна. Н.Ишжамц 1960-аад оны дундуур "БНМАУ-ын түүх" гурван боть, "БНМАУ-ын түүх"-ийн нэмж засварласан нэгэн боть хамтын бүтээлд монголын үндэсний эрх чөлөөний тэмцлийн түүхийн үндсэн гол бүлэг зүйлүүдийг бичилцсэнээс гадна дараагийн жилүүдэд уг сэдвийн судалгааг улам гүнзгийрүүлж олон чухал өгүүлэл бичиж нэлээд асуудлыг бас шинэлэг байдлаар авч үзсэн байна. Түүний судалгааг ажиглахад дараах цэгцтэй ойлголтыг өгч байдаг. Харин

1. XVII зууны үеэс эхлэн монголын ард түмэн Манжийн түрэмгийллийн эсрэг нэг биш удаа босон тэмцсэн.

2. XVII зууны Амарсанаа, Чингүнжав нарын зэвсэгт тэмцэл бол нийт халх, ойрадыг хамарсан Монголын үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцлийн хамгийн яруу тод илрэл нь болсон

3. Монголын ард түмний хэдэн зуун жилийн үндэсний эрх чөлөөний тэмцлийн үр дүн нь 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгал мөн.

4. 1911 оны хувьсгал XX зууны монголын үндэсний сэргэн мандлын эх суурийг тавьж өгсөн бөгөөд тэр нь октябрийн хувьсгалын дараах олон улсын харилцааны шинэ нөхцөлд улам баталгаажсан гэх мэт.

1970-аад оноос академич Н.Ишжамцын судалгааны сэдэв улам өргөжиж Монголын нэгдсэн төр улс, Чингис хаан, дундад зууны монголын нийгэм эдийн засгийн байгууллын асуудал руу түлхүү чиглэсэн харагдана. Тухайлбал 1974 онд "Монголд нэгдсэн төр байгуулагдаж, Феодализм бүрэлдэн тогтсон нь" гэдэг томоохон бүтээлээ хэвлүүлсэн байна. Тэр үеэс өнөөг хүртэл монголын эрт, Дундад үеийн түүхийн судалгааг орхисонгүй улам нарийвчлан судалж шинэ шинэ санаа дүгнэлтээр баяжуулсаар байна. Энэ чиглэлээр академич Н.Ишжамц "Монголын феодалын нэгдсэн төр байгуулагдахын урьдчилсан нөхцөл" /1973/, "Хамаг монголын хант улсын нэгдэл сэргэсэн нь" 1989, Монголын феодалын нэгдсэн улс, /1989/, "Монголын эзэнт гүрний нийгэм, улс төрийн байдал" /1991/, "Чингис ба түүний залгамжлагчдын аян дайн" /1990/ "Монголын анхны төр улс ба тусгаар тогтнолын асуудал" /1991/, "Монголын Юан улс" /1984/, "Монгол гүрний мөхөлт" /1984/ гэх мэт олон чухал судалгааг нийтлүүлсэн байна.

Академич Н.Ишжамц: "Монгол улсад анх ангит нийгэм, төр улс, нүүдэл иргэншил үүсэн бүрэлдэж, Чингис хаан Монголын олон аймгуудыг нэгтгэн нэгдсэн төр улс байгуулсаны дараа Монголын нүүдлийн Феодализм ба нүүдэл иргэншил хөгжлийн шинэ шатанд шилжсэн" хэмээн үздэг. Үүнийг Монголын түүх судлаачид үндсэндээ баримталсаар байна.

Академич Н.Ишжамц Чингис хаан, Монголын эзэнт гүрэн, түүний байлдан дагууллын асуудлыг судлахдаа хэт хараан шүүмжлэх эсвэл хэт дэвэргэн магтах туйлшралаас ангид байж асуудалд зөвхөн шинжлэх ухааны үндэстэй бодит байдлаар хандахыг хичээж ирсэн онцлогтой.

Чингис болон түүний залгамжлагчдын байлдан дагуулын тухай сүүлийн үеийн судалгаандаа сөрөг талуудыг дурдахын зэрэгцээ эерэг нааштай талыг товойлгон тодруулахад ихэд анхаарч ирэв. Тухайлбал Чингис ялангуяа Өгөдэй, Гүюг, Мөнх хааны үест Ази, Европыг дамнасан Монголын эзэнт гүрэн бий болсон нь Дорно-өрнө, Өмнө-умрыг Цэрэг-улс төр, худалдаа-эдийн засаг, зам харилцаа, шашин-соёлын талаар баттай холбож өгсөн томоохон үйл явдал болсон тухай, тэрхүү эзэнт гүрэн задарч Юан улс, Алтан ордоны улс тус тус байгуулагдаад тэдгээрийн хаад ноёд өөрсдийн захиргаан дахь газар орныг сэргээн хөгжүүлэх талаар хүчин чармайлт гаргасан тухай, тухайн үед Хятад, Иран, Туркестан, Оросын тус тусын нэгдмэл байдал сэргэн бэхжих үндэс суурь тавигдсан тухай, мөн тэдгээр орны дараах үеийн эрчимтэй

дэвшил хөгжлийн суурь тавигдсан зэрэг олон асуудлыг магадлан тодруулсан байдаг. Чингисийн тухай нилээд олон өгүүлэл бичихдээ түүнийг хувь хүний нь хувьд олон талаас нь чамбай судалж ажигласан байдаг. Чингис хаан улсын тэргүүн болмогц нэн түрүүн улс үндэстний язгуур эрх ашиг, тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баттай хангахад чиглэгдсэн алтан ургийн төрийн бодлогыг бий болгож, үеийн үед дагаж мөрдүүлэх уламжлалт тогтолцоог бүрдүүлж өгсөнийг онцлон тэмдэглэсэн байна. Чингис хааны шинж төрхийн зарим асуудалд” өгүүлэлд /Мөн түүний үнэн шударга ёс, дээд зэргийн ухаалаг уужуу сэтгэлгээг эрхэмлэж, эрдэм мэдлэгийг дээдлэн, эрдэмтэн мэргэжилтэй аливаа шашны дэвшилт зүтгэлтэн нарыг зохих ёсоор хүндэтгэн оновчтой хэрэглэж чаддаг онцлог шинж чанарыг товойлон дурдаад энэ онцлог чанар нь улс орноо мандуулахыг эрмэлзэгч хойч үеийн төр, цэргийн зүтгэлтэн нарт үлгэр дуурайлтайг онцлон сануулсан байдаг.

Академч Н.Ишжамц Чингис хааны мэндэлсэн он цагийг нарийн судалж нилээд үнэн магадтай товлон тодорхойлох оролдлого хийсэн эрдэмтдийн нэг юм.

Тэмүүжиний мэндэлсэн өдөр сар байтугай он жилийн тухай мэдээ сэлт түүхийн сурвалжид өвөр хоорондоо зөрөөтэй янз бүр байдгийг эрдэмтэн зурхайч хэсэг нөхдийн хамт нягтлан судалж, түүхийн сурвалж болон түүхэн уламжлал, элдэв цаг тооны бичгийн тусламжтайгаар 1162 оны 5-р сарын 31 нээр товлон тогтоох саналыг дэвшүүлсэн. Одоо сургууль соёлын байгууллагууд Чингисийн төрсөн он, сарын багцааг академичийн санал болгосноор товлон тэмдэглэх нь хэвшил болж байна.

Академич Н.Ишжамц Монгол угсаатан, үндэстэн хаана, хэзээ, хэрхэн үүсч бүрэлдсэн тухай нэлээд улгай судалгаа хийсэн эрдэмтэн юм.

XII зууны эцэс XIII зууны эхээр одоогийн нийт монголчуудын нутаг дээр оршин амьдарч байсан олонханлиг аймгууд цөм хамаг Монголын ханлиг ба язгуурын монгол аймгийн нэгэн адил монгол угсааны, монгол хэлтэн аймгууд байсныг, эдгээр олон аймаг овгууд нь түүний өмнөх үеийн Шивэй, Дунху, Хүннү, Сяньби, Моюн, Тоба, Жужан, Түрэг, Уйгур, Киргиз, Кидан нартайгаа удам угсаа, хэл соёлын уламжлалт харилцаа хамааралтай байсныг олон зуун жилийн турштэд цөм бие биендээ ямар нэг хэмжээгээр тархан ижилсээд монгол угсаатныг бүрэлдүүлсэн болохыг академич Н.Ишжамц хэд хэдэн судалгаандаа нотолсон байдаг. Мөн монголын төр ёсны уламжлал нь монгол нутагт байсан өмнөх үеийн улсуудын төр ёсны уламжлалтай нягт холбоотой бөгөөд Монголын нэгдсэн улс, эзэнт гүрэн түүнийг залган авч улам хөгжүүлж төгөлдөржүүлсэн хэмээн үзэж Монголын төр ёсны уламжлал хоёр мянга хоёр зуу гаруй жилийн түүхтэйг нэлээд олон судалгаандаа тодруулсан байна. 1970-аад оноос хойш "XIII-XIV зууны монголын соёл" /1978/, XII-XIII зууны Монголчуудын ёс заншил" /1974/, "XIII зууны монголын шашин шүтлэг" /1974/, "Азийн нүүдэлчид ба Хятад" /1975/, "Жужаны соёл ба Монгол" /1978/, "Монголын нүүдэл иргэншил,

сэргэн мандлын асуудал" /1991/, Төв Азийн иргэншилд Монголын соёлын эзлэх байр суурь" /1993/, "Нүүдэл хийгээд иргэншлийн тухай" /1993/, "Төв Азийн зүүн хэсгийн нүүдэлчид" /1994/ гэх мэт судалгааны олон өгүүлүүд бичжээ.

Монголд шарын шашин дэлгэрсэн явдлыг манж Чин улсын колончилох бодлоготой холбон тайлбарлах нь их байдаг. Гэтэл академич өөр нэг шинэ санааг нэлээд эрт дэвшүүлсэн байдаг. Энэ нь юу вэ гэвэл шарын шашин бол Төвдийн шашин. Төвдийн шашныг манж нар биш Монголчууд өөрсдөө авч дэлгэрүүлсэн. Уламжлалт соёл, зан заншил бүхий Төвдийн орны шашныг авсан явдалыг гаднын зарим суртал, улс төрийн нөлөөнд орохоос урьдчилан сэргийлэх, мөн улс үндэстний нэгдлийг бэхжүүлэх зорилготой байснаар тайлбарлаж байна.

Орчин үед нүүдэл иргэншил түүний хувь заяаны тухай асуудал олны анхаарлыг зүй ёсоор татсаар буй. Нүүдэл иргэншил цаашид монгол оронд байх эсэх, ер нь нүүдэл иргэншлийг хөгжүүлэх хэрэгтэй юү үгүй юү гэдэгт академич хоёрдмол утгагүй тов тодорхой хариулт өгсөн байдаг. Монголын нүүдэл иргэншлийн эх суурийг Хүннү нар тавьж өгсөн бөгөөд энэхүү олон зуун жилийн уламжлалт иргэншил Монгол нутагт цаашид оршин тогтнож, өрнө дорнын суурьшмал иргэншлийн шинжлэх ухаан-технологийн ололт амжилттай зохистой хослон хөгжих нөхцөл боломж улам нээгдэж байна. Иймд Монголын нүүдлийн соёл иргэншил мөхөх биш дэвшилт бүхнийг өөртөө шингээж суурьшмал иргэншилтэй хослон хоршин хөгжих ёстой хэмээн үзэж байна.

Шинэ сэргэн мандлын асуудлын хувьд уг үзэл санаа Монголд хэдүй үеэс хэрхэн үүсч эрчимжсэн. Монгол үндэстний сэргэн мандлын шинэ эрин эхэлж түүний шилжилтийн эхний хүнд үед улс орон чухам юунд анхаарах шаардлагатай байгаа тухай эрдэмтэн хүний хувьд Монголын түүхийн гүнзгий мэдлэгтээ тулгуурлан олон талаас нь нухацтай бодсон бодол сэтгэлээ дээрх өгүүлүүдэд нэг биш удаа шингээн бичсэн нь ажиглагддаг.

Академич Н.Ишжамц бол монголын гадаад харилцааны түүхийн мэргэжилтэн мөн гэж хэлж болно. Сүүлийн жилүүдэд академич Н.Ишжамц олон улс судлалын хүрээлэн дэх монголын гадаад харилцааны түүхийн судалгааг удирдаж "XII зууны монголын эзэнт гүрний гадаад харилцаа" 1994/, "XIV-XIX зууны монголын гадаад харилцаа" хэмээх хоёр хамтын бүтээлийг туурвилцаж хянан нягталж нийтлүүлсэнээс гадна "Монголын гадаад харилцааны түүхэн уламжлал" /1994/, "Монголын эртний гадаад харилцаа" /I-II зуун/ 1992, "XIV-XVII зууны Монгол улс, түүний гадаад харилцааны зарим асуудал" зэрэг хэд хэдэн томоохон судалгааны өгүүлэл бичсэн байна. Н.Ишжамц монгол улсын гадаад харилцааг судлахдаа түүний түүхэн уламжлалаас эхлэн судалсан байдаг. Хүннү гүрэн, Сяньби улсын үед монголын төр улс, гадаад харилцааны түүхэн замналын үндэс суурь нэгэнт тавигдсан гэж үздэг. Хүннү, Түрэгийн үеийн гадаад харилцаа, Их монгол улс

түүний дараах үеийн гадаад харилцааг нэлээд судалсан байна. Эзэнт гүрэн мөхсөний дараа Монголын төр ёс, гадаад харилцааны уламжлал тасарсангүй, цаашид XVII, XVIII зууныг хүртэл тасралтгүй үргэлжлэн хөгжсөөр байсан юм. XVII-XVIII зууны үед Манжид эзлэгдсэн явдал монголын төрийг мөхөөж ихээхэн хор хохирол учруулсан боловч монголын төр ёс, нүүдэл иргэншил, гадаад харилцааны уламжлалыг бүрмөсөн таслан устгаж хараахан чадаагүй. Энэ нь Монголд үндэсний эрх чөлөөний хувьсгал ялж тусгаар тогтнолоо тунхаглан, гадаад харилцааны нарийн бодлого, Дипломатын чадамгай үйл ажиллагаа бэлэн зэлэн явуулсанд тусгалаа олсон гэж үздэг. XIV-XIX зууны үеийн монголын гадаад харилцааг үзэхдээ Юан улс мөхсөний дараа Хархорум хот, Халх, Цахар, Ойрадад төвлөж XVII-XVIII зууныг хүртэл оршин тогтнож байсан нэгэн үе, манжид эзлэгдсэн өөрийн гэсэн төр засаггүй болсон орон нутгийн ёсоор оршин байсан XVII-XIX зууны нөгөө нэгэн үе хоёрыг ялган салгаж үзээд эхний үе нь тусгаар тогтнож биеэ даасан улсын гадаад харилцаа байсан. Дараагийн үе нь Монгол улс феодалын бутралд автан Зүүн Баруун монгол, дараа нь Зүүн монгол дотроо Зүүн баруун түмэн ба Ойрад гэх зэргээр хэд хэдэн Хант улс болон хуваагдсан бөгөөд өөр хоорондын харилцааг улс түмэн тус бүрийн нь хувьд гадаад харилцааны шинжтэй байсан боловч нэгэнт Монгол улс, монгол орон, монгол үндэстний хувьд дотоод харилцаа, дотоодын асуудал байсан, түүнчлэн манжид эзлэгдсэний дараа Монгол, Хятад, Төвд, Дорнод Туркестан, Манж нар цөм Чин улс хэмээх нэгэн их гүрний дотор оршин амьдрах болсон тул тэдний хоорондын харилцааг бүхэл бүтэн Манж Чин гүрний хувьд дотоодынх мэт боловч монгол орны хувьд гадаад харилцаа байсан гэж үзэж буй.

Москвагийн их сургуулийн түүхийн ангийг хятад судлалын мэргэжлээр төгссөний хувьд академич Н.Ишжамц Хятадын түүхийг сонирхож Хятад гүрэнд болж буй үйл явдал, ялангуяа хятадын түүх судлалд гарч буй зарим үзэгдлийг судлан шинжлэх ажлыг хийсээр иржээ. 1980-аад оны дундуур Хятадын түүхийн сурвалж баримт, судалгааны зохиолоос эхлэн нийт Хятадын түүхийн тоймыг үе үеэр нь ялган салгаж, нэгтгэн дүгнэсэн цуврал өгүүллийг Дорнодахины судлалын асуудал сэтгүүлд хэвлүүлсэн байдаг. Түүнчлэн цаг үеийн шаардлагаар Их Хятадын дээрэнгүй үзэл, Маоизмын эсрэг үзэл суртлын тэмцэлд татагдан орж "Маогийнханы түүх-археологийн түрэмгийлэл", "монголын түүхийг маогийнхан завхруулж байгаа байдал ба түүхэн үнэн" гэх мэт товхимолуудыг эрдэмтэн Ш.Бира, Ш.Сандаг нартай хамтран туурвиж тухайн сэдвээр судалгааны нэлээд олон өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.

Академич Н.Ишжамц бол эрдмийн ажлыг авъяаслаг удирдан зохион байгуулагч мөн. 1960-аад онд түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хэлтсийн эрхлэгч, 1977 оноос Дорнодахины судлалын хүрээлэнгийн орлогч захирал, 1984-1990 онд мөн хүрээлэнгийн захирлын ажилд тус тус томилогдон ажиллаж 1991 оноос АНУ судлалын Төвийн

зохион байгуулалтын ажлыг толгойлон явуулж байна.

Мөн сурган хүмүүжүүлэгч гэж хэлж болно. Учир нь Монголын түүхийн хэд хэдэн сурах бичгийг Х.Пэрлээ, М.Санждорж нарын хамт туурвиж хэвлүүлсэн бөгөөд 1953-1954 онд Намын Дээд сургуульд монголын түүх, 1973-1992 онд Улсын их сургууль, Багшийн Дээд сургуульд Монгол, Хятадын түүх зааж байв.

*Академич Н. Ишжамцын судалгааг ажиглахад:*

1-рт монголын түүхийн бараг бүхий л үеийг хамарсан өргөн цар хүрээтэй сэдвээр судалгаа хийдгээр онцлог байна.

2-рт монголын түүхийн судалгааны хэд хэдэн чиглэлд илүүтэй анхаарсан үзэгдэнэ.

Үүнд:

-Монголын ард түмний тусгаар тогтнолын тэмцэл, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухай

-Монголын нэгдсэн төр улс, Монголын эзэнт гүрэн, Чингис хааны тухай

-Монгол угсаатан үүсч бүрэлдсэн түүх ба төр ёсны уламжлалын тухай

-Монгол, Төв Азийн соёл иргэншил, үндэсний сэргэн мандлын тухай

-Монголын гадаад харилцааны түүхийн тухай -Хятад судлал гэх мэт

Эдгээр 6 чиглэлээр үлэмжхэн судалгааг хийжээ. Академич Н.Ишжамцын бичиж хэвлүүлсэн эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт зохиол, товхимол, бусадтай нийлж бүтээсэн хамтын бүтээлийн тоо 20 гаруй, редакторлосон ном, сэтгүүл 20 гаруй, эрдэм шинжилгээний дорвитой өгүүлэл, шүүмж 100 илүү байна.

3-рт Академич Н.Ишжамцын судалгааны санаа дүгнэлтүүд ихэнхдээ Монголын түүхийн шинжлэх ухааныг баяжуулж, олонхи нь нийтээр хүлээн зөвшөөрсөн албан ёсны үзэл баримтлал болсоор байдаг нь монголын шинжлэх ухааны зүй ёсны том зүтгэлтэн мөн гэдгийг баталж байна.

Академич Н.Ишжамцын нөр их хөдөлмөр, шинжлэх ухаанд оруулсан үнэтэй хувь нэмрийг Монгол улсын төрөөс өндөр үнэлэн 1981 онд хөдөлмөрийн хүндэт медаль, 1996 онд шинжлэх ухааны гавъяат ажилтан цол олгожээ.

Нас сүүдэр 70 зэрэгцэж байгаа энэ эрдэмтэн, одоо ч гэсэн монголын түүхийг судлах ажлаа эрчимтэй хийж олон чухал шинэ санаа дэвшүүлж, үр бүтээлтэй ажилласаар байна.

Шинжлэх ухааны гавъяат ажилтан академич проф. Доктор Нямбуугийн Ишжамцын 70 насны ойг тохиолдуулан эрдэмтэн судлаачдынхаа өмнөөс ажлын улам их амжилт, эрүүл энх хүсэн ерөөж байна.